



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/023

Номгон

“Ажлын байранд хүүхэд хөхүүлэх, живх солих өрөө бий болгох” аян зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дүгээр заалт, Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор баталсан “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй-хөгжил” төслийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ажлын байранд хүүхэд хөхүүлэх, живх солих өрөө бий болгох” аяны удирдамжийг нэгдүгээр, болзолт уралдааныг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Ажлын байранд хүүхэд хөхүүлэх, живх солих өрөө бий болгох” аяны үйл ажиллагааны тайланг 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлд тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Б.Наранбаяр/-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Д.Энхжаргал/-т даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210455

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар  
сарын 05-ны өдрийн А/623 дугаар захирамжийн  
1 дүгээр хэвсрэлт



**“АЖЛЫН БАЙРАНД ХҮҮХЭД ХӨХҮҮЛЭХ,  
ЖИВХ СОЛИХ ӨРӨӨ БИЙ БОЛГОХ” АЯНЫ  
УДИРДАМЖ**

**Нэг. Үндэслэл**

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй-хөгжил” төслийг хэрэгжүүлэн ажилласнаар НҮБ-ын Хүүхдийн сан, Үндэсний статистикийн хорооноос 2019 онд зохион байгуулсан “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр” судалгаагаар ангир уургаар амлуулалт улсын дунджаас 4.1 хувиар өндөр, 0-6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллолт 22.9 хувиар өндөр, 06-23 сар хүртэл эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт 5.1 хувиар өндөр, нялхсын сүүн тэжээлийн хэрэглээ 5 хувиар бага, угжны хэрэглээ 17.9 хувиар бага гэж үнэлэгдсэн.

Аймгийн эхийн сүүгээр хооллолтын байдал 2020 онд 1 цагийн дотор ангир уургаар амлуулалт 97.1 хувь байгаа нь өмнөх оноос 0.7 хувиар, 0-6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллолт 73.4 хувь буюу өмнөх оноос 0.4 хувиар, 06-23 сар хүртэл эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт 77 хувь буюу 1 хувиар өссөн зэрэг үзүүлэлттэй байгаа хэдий ч ажлын байранд эх хүүхдээ хөхүүлэх, живх солих орчин бүрдүүлсэн аж ахуйн нэгж байгууллага байхгүй байна.

Иймд аж ахуйн нэгж, байгууллагуудыг нялх, бага насны хүүхэдтэй албан хаагч ажил дээрээ хүүхдээ ирүүлэн хөхүүлэх, живхийг нь солих, саасан хөхнийхөө сүүг хадгалах өрөө бий болгон тохижуулахыг уриалж нэгдүүлэх шаардлагатай байна.

**Хоёр. Зорилго**

Аж ахуйн нэгж, байгууллагуудад нялх, бага насны хүүхэдтэй эх асран хамгаалагчдыг ажил дээрээ хүүхдээ ирүүлэн хөхүүлэх, живхийг нь солих, саасан хөхнийхөө сүүг хадгалах боломжоор ханган өрөө бий болгохыг уриалах, арга зүйгээр хангах, идэвхжүүлэх, урамшуулахад аяны зорилго оршино.

**Гурав. Зорилт**

-Аж ахуйн нэгж байгууллагуудыг хүүхэд хөхүүлэх, живх солих өрөө бий болгохыг уриалан арга зүйгээр ханган ажиллах.

## 2.

-Хүүхэд хөхүүлэх, живх солих өрөөг жишиг байдлаар тохижуулсан аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулан шагнаж урамшуулах, олон нийтэд сурталчлан таниулах.

### **Дөрөв. Хамрах хүрээ**

Баянхонгор аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд

### **Тав. Хамтран зохион байгуулагч**

-Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

-Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар

-НҮБ-Хүүхдийн сан, БНСУ –ын ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага, “Коиса”-ын санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, эрүүл ахуй, ариун цэвэр эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл

### **Зургаа. Хүрэх үр дүн**

- Аж ахуйн нэгж байгууллагууд өрөө тохижуулах арга зүйгээр хангагдан эх, асран хамгаалагчид, хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулснаар эх хүүхдээ ажлын байранд хөхүүлэх боломжтой болж эхийн сүүгээр хооллолтын байдал нэмэгдэж суурь өвчлөл буурна.

-Жишиг байдлаар тохижуулсан өрөөг олон нийтэд сурталчлан танилцуулснаар иргэд олон нийт эх хүүхдэд ээлтэй орчин бий болгох сэдэл төрнө.

### **Долоо. Хугацаа**

“Ажлын байранд хүүхэд хөхүүлэх, живх солих өрөө бий болгох” аяныг 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл өрнүүлнэ.

### **Найм. Аяны тайлан ирүүлэх**

Аяны тайланг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн дотор Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /Д.Мөнх-Эрдэнэ/-д албан бичгээр ирүүлнэ.

### **Ес. Өрөөнд тавигдах шаардлага**

Аж ахуйн нэгж байгууллага нь хүүхэд хөхүүлэх, живх солих өрөөг тусгайлан гаргаж доорх тавилга хэрэгслийг байршуулан тохижуулна.

### **Үүнд:**

-Хаалганы хаягжилт/Эх, хүүхдийн өрөө/

3.

-Эх хүүхдийн өрөөгөөр үйлчлүүлэх албан хаагчдын мэдээллийг байршуулсан байх.

-Хөшиг

-Гар ариутгагч

-Угаалтуур /саван, хатаагч байршуулах/

-Хогийн сав/гишгэж онгойдог, тагтай/

-Хүүхэд хуурайлах давцан/ор/

-Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй

-Ус буцалгагч

-Хөргөгч /эхийн сүү хадгалах/

-Ном гарын авлага байршуулсан булан, тавиур

-Ширээ, сандал/ хүүхэд хөхүүлэхэд тохиромжтой, хурц ирмэг үзүүргүй байх/

-Өрөөний температур хэмжигч/ өрөө 18С-23С хэмтэй байна/

-Хүүхэд саатуулах тоглоом

-Хүүхдийн хашлагатай ор

**Жич:** Хүүхдийн өрөөтэй бол тус өрөөгөө нэмэлтээр тохижуулж болно. Эхийн сүүгээр хооллолт, хооллолтын ач холбогдлын талаар гарын авлага зурагт хуудсыг доорх цахим хаягнуудаас авна.

-Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, <http://www.ncph.gov.mn/>,

-Баянхонгор эрүүл мэндийн газар <http://www.bayankhongor.moh.gov.mn/>

**Арав. Шалгаруулалт, шагнал, урамшуулал**

Баянхонгор сумаас оролцогч аж ахуйн нэгж байгууллагуудад ажлын хэсэг очин, бусад сумын албан байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй цахимаар холбогдон удирдамжид заасан өрөөнд тавигдах шаардлагын дагуу дүгнэнэ.


Аяны тайлан ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудаас хүүхдэд ээлтэй, жишиг байдлаар тохижуулсныг харгалзан үзэж **тэргүүн, дэд, гутгаар байр** тус тус нэгийг шалгаруулан доорх байдлаар шагнаж урамшуулна.

Тэргүүн байр- Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Дэд байр-Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Гутгаар байр-Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар  
сарын 05-ны өдрийн А/623 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт



**“АЖЛЫН БАЙРАНД ХҮҮХЭД ХӨХҮҮЛЭХ, ЖИВХ СОЛИХ  
ӨРӨӨ БИЙ БОЛГОХ” АЯНЫ БОЛЗОЛТ УРАЛДААНЫГ  
ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Наранбаяр -Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Нарийн бичгийн дарга:**

Д.Мөнх-Эрдэнэ -Эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний  
аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн.

**Гишүүд:**

Б.Содончимэг -Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын  
Хүүхдийн эрхийн улсын байцаагч

М.Баярбаясгалан -Эрүүл мэндийн газрын Өсвөр үе, нөхөн үржихүйн  
эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн.

Ш.Ариунцэцэг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн Төслийн зохицуулагч

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_